



ОРХОН АЙМГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТАНИЛЦУУЛГА

2026 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 01

Баян-Өндөр сум

ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
2025 ОНЫ 04-Р УЛИРЛЫН ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2026 оны 01-р сарын 08-ны өдөр

Орхон аймаг

Нэг. Хяналтын үндэслэл

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн 02/529 тоот албан даалгаврын дагуу Шилэн дансны тухай хууль тогтоомж, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журамд үндэслэнэ.

Хоёр. Хяналтын зорилго

Шилэн дансны цахим хуудасны Нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын үйл 2025 оны 04 дүгээр улирлын хөтлөлт, мэдээлэл байршуулсан байдал, холбогдох шийдвэрийн хуулбар, баримт бичгийг бүрэн оруулсан эсэхэд хяналт хийж, зөрчлийг арилгуулахад зорилго оршино.

Гурав. Хяналтын хамрах хүрээ

Шалгалтыг 2025 оны 04 дүгээр улирлын Шилэн дансны цахим хуудсанд Нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл байршуулсан байдал, холбогдох шийдвэрийн хуулбар, баримт бичгийг бүрэн оруулсан эсэхэд 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 2026 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн хооронд хугацаанд Нийгмийн даатгалын газрын Захиргаа, хяналтын хэлтсийн дарга Г.Галбадрах, Хяналт шалгалтын улсын байцаагч Ц.Болорцэцэг, Г.Мичидмаа нар шалгалтыг хийж гүйцэтгэн ажилласан.

Дөрөв. Шилэн дансны хөтлөлт, мэдээлэл байршуулсан байдал

- Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын үйл ажиллагааны шилэн дансны нийт 171 мэдээлэл оруулахаас хагас жилийн байдлаар хугацаандаа оруулсан мэдээлэл 165, хугацаа хоцорсон мэдээлэл 1, мэдээлээгүй 5 байна
- Орхон аймгийн Нийгмийн даатгалын сангийн шилэн дансны нийт 159 мэдээлэл оруулахаас хагас жилийн байдлаар хугацаандаа оруулсан мэдээлэл 157, хугацаа хоцорсон мэдээлэл 0, мэдээлээгүй 2 байна.

Тав. Хяналтын үр дүн

Үйл ажиллагааны мэдээлэл оруулахдаа:

- Сар бүр, жил бүр, тухай бүр оруулах мэдээний хавсралт цэсэд мэдээлэл байршуулаагүй, хавсралтад оруулах мэдээллээ дутуу, буруу оруулж тайлагнасан боловч тухай бүр оруулах мэдээллээ сүүлийн саруудад хоцролгүй оруулж байгаа сайн талтай байна.
- Мэдээлэл байршуулсан хувь:
Нийт мэдээлэл байршуулсан хувь-98%
Хугацаандаа мэдээлэл байршуулсан хувь-90%

Сангийн мэдээллийн оруулахдаа:

- Тухай бүр оруулах мэдээллийг хугацаа хоцорч оруулах, оруулах мэдээллийг давхар бүртгэж илүү оруулах зэрэг алдаанууд байна.
- Мэдээлэл байршуулсан хувь:
Нийт мэдээлэл байршуулсан хувь-100%
Хугацаандаа мэдээлэл байршуулсан хувь-94%

Зургаа. Шилэн дансны мэдээлэл байршуулалттай холбоотой илэрсэн зөрчил

Үйл ажиллагааны шилэн дансны дансны мэдээлэлд:

1. Сар бүр, жил бүр, Тухай бүр оруулах мэдээний хавсралт цэсэд мэдээлэл байршуулаагүй тайланг оруулсан, өмнөх улирлаас хоцорсон мэдээллийн тоог бууруулж хугацаа хоцроогоогүй байна.
2. Төсвийн хэтрэлт хэмнэлтийн тайлбарыг бүрэн оруулаагүй тайлагнасан.

Сангийн шилэн дансны дансны мэдээлэлд:

1. Жил бүр, Тухай бүр оруулах мэдээний хавсралтад цэсэд мэдээлэл дутуу оруулж тайлагнасан.
2. Жил бүр, Тухай бүр оруулах мэдээний хавсралтад цэсэд мэдээлэл дутуу оруулж, Тухай бүр оруулах мэдээллийн байршуулалтад гарсан алдаа:

НДЕГ-ын ДАМГ-аас 2025 оны 11 дүгээр сард хийсэн шалгалтаар дутуу мэдээлсэн нийт 32 гүйлгээний 22,865.6 сая төгрөгийн гүйлгээний зөрчлийг арилгасан боловч үүнээс гадна шалгалтын явцад илүү мэдээлсэн 92 гүйлгээний 8,381.1 сая төгрөгийн мэдээллийг засаж, дутуу мэдээлсэн 4 гүйлгээний 921.7 сая төгрөгийн гүйлгээг нөхөн байршуулж нийт 96 гүйлгээний 9,302.8 сая төгрөгийн гүйлгээний зөрчлийг арилгасан.

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээ	Хяналт шинжилгээний явцад зөрчлийг арилгаж нөхөн байршуулсан мэдээлэл /Сая.төгрөг/		Илүү мэдээлсэн дүн /Сая.төгрөг/		Дутуу мэдээлсэн дүн /Сая.төгрөг/	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлогын мөнгөн гүйлгээ	82	7,110.4	80	6,202.3	2	908.1

Зарлагын мөнгөн гүйлгээ	14	2,192.4	12	2,178.8	2	13.6
-------------------------	----	---------	----	---------	---	------

Долоо. Зөвлөмж

Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулгыг харгалзан оруулах мэдээлэл байхгүй үед шалтгааныг нь тайлбарлан бичиж, дарааллын дагуу бүх цэсийг бүрэн дарж баталгаажуулах, мэдээ оруулах хуулийн хугацааг өдөр бүр орж шалгаж хэвшсэн боловч хэмнэлт хэтрэлтийн тайлбарыг бүрэн гүйцэт бичиж оруулдаггүй, тухай бүр оруулах мэдээллийг шийдвэр гарсны дараа 7 хоногийн дотор байршуулж, хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой тушаал шийдвэрийг нягтлан бодогчид 5 хоногийн дотор өгч хэвшсэн, хавсралт цэстэй байгаа мэдээлэлд хавсралтыг бүрэн оруулж цаашид алдаа дутагдлаа давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах, Сангийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн албан тушаал дээр ажиллаж байгаа 2 албан хаагчийн мэдээлэл байршуулах ур чадварын ялгаатай байдлаас шалтгаалан цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээг дутуу оруулах алдаа нэмэгдсэн тул ур чадварыг нэмэгдүүлэх, алдааг гаргахгүй байхад чиглэсэн сургалтыг үр дүнтэй зохион байгуулах

Найм. Дүгнэлт

Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын дагуу үйл ажиллагааны болон нийгмийн даатгалын сангийн нийт 330 мэдээллээс сар, улирал бүр, эхний хагас, бүтэн жилээр оруулах мэдээллээс хуулийн хугацаанд 306 мэдээллийг байршуулсан боловч 24 мэдээллийг хугацаа хоцроож тайлагнасан. Өмнөх зөвлөмжийн дагуу ажлын хуваарилалтаа өөрчлөн 1 албан хаагч оруулдаг байсан ачааллыг бууруулж 2 албан хаагч болгож сайжруулсан боловч алдааны тоо нэмэгдсэн байна.

Ес. Цаашид авах арга хэмжээний санал

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл оруулах дээд шатны байгууллагаас өгсөн зөвлөмжийг заалт бүрээр мөрдөж ажиллах
2. Цаашид мэдээлэл хоцроохгүй байхад чиглэсэн ажлын хуваарилалтаа сайжруулах арга хэмжээ авахдаа тухайн албан хаагчийн ур чадварыг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулж, алдаа гаргахгүй байхад анхаарч ажиллах
3. Ахлах нягтлан бодогчийн хяналтыг сайжруулах

ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН:

ЗАХИРГАА, ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Т.ГАЛБАДРАХ

ТАНИЛЦСАН:

САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
БӨГӨӨД АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

